

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

“УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ-2023” СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Дундговь аймгийн хөгжлийг тодорхойлоход манлайлал, уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, нэгдсэн мэдээллээр хангах зорилгоор “Удирдлагын манлайлал-2023” хурал, зөвлөгөөнийг энэ сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалт зөвлөгөөнд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Байгууллагын дарга, эрхлэгч нар, Санхүүгийн албаны дарга нар оролцлоо.

Энэ үеэр илтгэлүүд болон жишиг сум, байгууллагуудын туршлагаас суралцсан юм. Мөн салбар хуралдаанууд, нөхөрсөг спортын тэмцээнийг зохион байгуулагдаж, оролцогчдоос мэдлэг бататгах сорилуудыг авсан нь зөвлөгөөнийг үр дүнтэй, оролцоотой болгосон байна.

БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР ГАРДУУЛЛАА



Аймгийн Засаг даргын Тамгын газар Статистикийн хэлтэс хамтран сумдын багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, статистик хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг 11-р сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтад 15 сумын 79 албан хаагч оролцов.

Сургалтаар Үндэсний статистикийн хорооноос Мал, тэжээвэр амьтдын тооллогын зохион байгуулалт, мэдээллийн чанар сайжруулахад анхаарах

асуудлаар илтгэлүүдийг тавьсан бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Доржбат аймаг орон нутагт хийж, хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлэл хийсэн юм. Мөн мал тооллогын маягтын архивлалт, багийн түвшинд иргэдийн оролцоог хангах талаар, 2023 оны зуншлагын тойм, бэлчээрийн даац багтаамж, өвөлжилтийн нөхцөл байдал, малын вакцинжуулалт, цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын талаар цаг үеийн болон шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг хүргэжээ.


Түүнчлэн энэ үеэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Эрдэнэ, Засаг дарга Ц.Мөнхбат, Засаг даргын Тамгын газрын дарга Л.Доржбат сургалтад оролцогчидтой хэлэлцүүлэг өрнүүлэн, тэдний санал хүсэлтийг сонссон байна.

Сургалтын үеэр Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат багийн Засаг дарга нарт 400 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 66 багийн даргад иж бүрэн зөөврийн компьютер, 40 багийн Засаг даргад туулах чадвар сайтай мотоцикл гардууллаа.

ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Сангийн яамтай хамтран “Орон нутгийн байгууллагын санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт”-ыг Дундговь аймгийн орон нутгийн санхүүгийн нийт 78 албан хаагчийг хамруулан Улаанбаатар хотноо 2023 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтанд манай байгууллагын Санхүүгийн албаны дарга Б.Доржханд, ЗДТГ-ын нягтлан бодогч Г.Нямсүрэн, Э.Сумъяажаргал, Нярав Э.Лхагвасүрэн нар оролцож шинэчлэн ашиглаж буй санхүү бүртгэлийн программ, бусад цахим системийн заавар зөвлөгөөг авч, түүнчлэн сайжруулах шаардлагатай саналуудаа хүргэж ажилласан байна.

Мөн HR Consulting клубын Хүний хөгжлийн сургалтад хамрагдаж Харилцаа хандлагын талаарх мэдлэг мэдээллийг олж авсан.





БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, ЁС ЗҮЙ СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Байгууллагын соёл, ёс зүй сэдэвт сургалт Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч Монгол улсын зөвлөх багш Г. Мөнхтуяа уригдан ирж явууллаа. Тус сургалтад сумын ЗДТГ-с гадна Ерөнхий боловсролын сурууль, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчид хүрэлцэн ирж нийт 40-д хүний бүрэлдэхүүнтэй үр өгөөжтэй сургалт болж өндөрлөлөө.

Сургалтыг зохион байгуулсан сумын ЗДТГ



МОНГОЛ БИЧГИЙН МОДУЛЬ СУРГАЛТ

АЛБАН ХААГЧИД МОНГОЛ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА.

Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд сумын Хэлний бодлогын салбар зөвлөлөөс Төрийн байгууллагын ажилтан албан хаагчдад үндэсний бичгийн түвшин ахиулах монгол бичгийн модуль сургалт зохион байгуулагдаж байна.



“БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”-2023 АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

“Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил”, “Үндэсний бичиг үсгийн баяр-2023” арга хэмжээний хүрээнд сумын Хэлний бодлогын зөвлөлөөс Төрийн байгууллагын албан хаагчид, иргэдийн дунд Сайхан бичигтэн, Алтан хонх, Хурдан уншигч, Цахим бичвэрийн сургалт төрлөөр зохион байгуулагдлаа.

Эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа суртачлах энэхүү Үндэсний бичиг үсгийн баярт манлайлан оролцсон

С.Сугирсүрэн, Х.Адьяасүрэн, Э.Ганчимэг, Б.Сувдаа, Э.Эрдэнэсүх, Ч.Бүрэнжаргал, Б.Жаалхүү, С.Отгонсүрэн, идэвхи санаачилгатай оролцож уралдааны нийт дүнгээр шилдэг байгууллагаар шалгарсан Цэцэрлэгийн хамт олонд баяр хүргэж, нийт оролцсон албан хаагч, иргэддээ баярлалаа.



